

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИК

Д. Тунгалаг*

Олон улсын хөдөлмөрийн байгууллага

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ) Версалийн энх тайвны гэрээгээр анх 1919 онд байгуулагдсан ба түүний олон улсын бусад байгууллагуудаас ялгагдах онцлог гэвэл харьяа байгууллагуудад нь байдаг төлөөлөгчийн газрын үндсэн гурван талын (ОУХБ-ын гишүүн орнуудын засгийн газрын төлөөлөгч; үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөлөгч; үйлдвэрийн эздийн үндэсний байгууллагын төлөөлөгч) зарчим юм.

ОУХБ-ын дүрмээр гурван тал тус бүр нөгөө хоёроосоо үл хамаарч биеэ даасан байдаг. ОУХБ-ын гол байгууллагууд нь жил болгон явагддаг Ерөнхий бага хурал, 3 жил тутам сонгогддог Засаг захиргааны зөвлөл, ерөнхий захирлаар толгойлуулсан Олон улсын хөдөлмөрийн товчоо (ОУХБ-ын нарийн бичгийн газар) юм. ОУХБ-ын төв нь Женевт (Швейцари) байрладаг ба түүний бүрэлдэхүүнд Аддис-Абеб, Бангкокд байдаг бүсийн хоёр хөдөлмөрийн товчоо, улс орнуудын 20 төлөөлөгчийн газар багтдаг. 1946 оноос ОУХБ нь НҮБ-ын статистикийн нарийн бичгийн газрын бүсийн дэд бүлэг болсон.

ОУХБ-ын үндсэн зорилтууд:

- ажлын цагийн дүрэм (регламентац) тогтоох;
- ажиллах хүчний дүрэм (регламентац) тогтоох;
- ажилгүйчүүдтэй хийх тэмцэл;
- амьдралын энгийн нөхцлийг хангах цалин хөлсний хэмжээг тодорхойлох;
- мэргэжлийн өвчин, үйлдвэрлэлийн ослоос хамгаалах;
- ажиллаж байгаа хүүхэд, эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах;
- нийгмийн даатгал, нийгэм хангамжийн асуудлыг зохицуулах;

* МУИС-ийн ОУХБ-ийн дэд профессор, доктор (Ph.D)

- техник мэргэжлийн сургалтыг зохион байгуулах.

Энэ зорилтуудыг шийдвэрлэх механизм нь:

- ажиллагсдын хөдөлмөрлөх болон амьдрах нөхцлийн асуудлуудаар нормчлогдсон актуудыг боловсруулж хэрэглэх замаар хөдөлмөрийн олон улсын эрх зүйн зохицуулалтад оролцох. Тусгай салбар хороод улсуудын эдийн засгийн хөгжлийн (тухайлбал, металлург, хими, нефть, нэхмэл болон бусад салбаруудын) нийгмийн үзэл бодол (аспект) -ыг тодорхойлох, зэрэгцүүлэх ажлыг гүйцэтгэх;
- нийгмийн болон хөдөлмөрийн талаарх асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн олон улсын зорилтот программыг боловсруулах, хэрэгжүүлэх (эдгээр зорилтуудыг шийдвэрлэх асуудлыг Женевт байрладаг Нийгэм болон хөдөлмөрийн асуудлыг судлах Олон улсын институт хариуцдаг);
- судалгааны ажил явуулах;
- хэвлэн нийтлэх үйл ажиллагаа явуулах;
- улс орнуудад хөдөлмөрийн хууль дүрмийг боловсронгуй болгоход тусламж үзүүлэх;
- техник мэргэжлийн бэлтгэлийг дээшлүүлэх Олон улсын төвийн хэмжээнд мэргэжлийн боловсролыг хөгжүүлэх (Италийн Турин хот).

Мэдээллийг цуглуулах, хөдөлмөрийн салбарт арга зүйн боловсруулалтыг дэлхийн түвшинд хэрэгжүүлэх ерөнхий зарчмыг тодорхойлсноор ОУХБ-ын дээр дурьдсан үйл ажиллагааг нэгтгэж болно. Ингэснээр ОУХБ нь дэлхийн түвшинд хөдөлмөр, ажил эрхлэгсдийн талаарх өргөн мэдээллийг өгөх бололцоог олгодог. ОУХБ нь дараах чиглэлээр статистикийн аргачлалыг боловсруулж байна.

Үүнд:

- мэргэжлийн бэлтгэл;
- ажиллагсад, ажилгүйчүүд;
- нийгмийн даатгал;
- ажлын долоо хоногийн үргэлжлэх хугацаа;

- үйлдвэрлэлийн осол;
- хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс;
- ажил хаях хөдөлгөөний статистик;
- цалин хөлсний статистик.

Дээрх чиглэлүүдээр ОУХБ-аас хөдөлмөрийн статистикийн жил бүрийн эмхтгэл, хөдөлмөрийн талаарх тогтмол бюллетенүүд, ажиллагсад, цалин хөлсний статистикийн эмхтгэлүүдийг гаргаж байна. 1991 онд ОУХБ нь цалин, хөлс, ажлын долоо хоногийн үргэлжлэх хугацаа, хэрэглээний үнийн түвшин гэсэн 3 үзүүлэлтээр 140 орныг ангилсан “Аравдугаар сарын судалгаа” нэртэй дэлгэрэнгүй судалгаа хийсэн.

Хөдөлмөрийн олон улсын статистикийн хөгжилд ОУХБ-ын хүрээнд бэлтгэгдсэн дэлхийн 157 орны статистикийн аргачлалын үндсийг тодорхойлсон судалгааны чанартай танилцуулга үнэтэй байр эзэлдэг. Түүнээс гадна ОУХБ-ын одоо мөрдөж байгаа олон улсын статистикийн стандартын хүрээнд үндэсний хөдөлмөрийн статистикийн аргуудыг зэрэгцүүлэх чиглэлээр маш чухал ангиллуудыг боловсруулан гаргасан. Тухайлбал:

- Салбарын олон улсын стандарт ангилал;
- Ажиллагсдын олон улсын стандарт ангилал;
- Хөдөлмөрийн нөөцийн олон улсын стандарт ангилал.

Хөдөлмөрийн нөөцийн үндсэн категориуд Хөдөлмөрийн нөөцийн үндсэн категори нь хөдөлмөр эрхэлдэг хүн ам, эдийн засгийн идэвхтэй хүн ам гэсэн 2 категорид хуваагддаг хөдөлмөрийн насны хүн амын тоо юм. Олон улсын статистикт “нийт хөдөлмөрийн нөөц” гэсэн нэр томъёо хэрэглэгддэг. Дээрх категори бүрийг авч үзье.

Хөдөлмөрийн насны хүн амд 15-64 насны хүн ам орох бөгөөд энэ үзүүлэлтийн насны хязгаарын хувьд үндэсний ялгаа гарч ирдэг.

Улс орны хөгжлийн түвшин ба хөдөлмөрийн насны хүн амын насны хязгаар хоорондоо салшгүй уялдаа холбоотой. Улс орны хөгжлийн түвшин хэдий чинээ өндөр байна, хөдөлмөрийн насны хүн амын насны доод хязгаар төдий чинээ өндөр, дээд хязгаар төдий чинээ нам байдаг.

Хөдөлмөрийн насны хүн амын насны хязгаар олон улсын хэмжээнд өөрийн орны онцлог, ёс заншлыг харгалзан хууль эрхийн актаар тодорхойлогддог. Тухайлбал: хөдөлмөрийн насны хүн амын насны доод хязгаар ОХУ, АНУ, Өмнөд Африкт 16 байхад Франц, Англи, Япон, Азербайджанд 15, Казакстанд 14, Пакистанд 12, Бенинд 10, Египетэд 6 байх жишээтэй. Дээд хязгаар нь (тэтгэврийн насны хязгаар) ОХУ, Монголд эмэгтэй 55, эрэгтэй 60, Англид 60 ба 65, АНУ, Баруун Герман, Канад, Испанид эрэгтэй, эмэгтэй адил 65 байдаг. Дэлхийн бүх улс орнуудын хувьд хөдөлмөрийн насны хүн амын тоонд хөдөлмөрийн насны ажил хийдэггүй тахир дутуу хүн ам ордоггүй.

Хөдөлмөр эрхэлдэг хүн ам гэсэн нэр томьёо статистикийн практикт бараг хэрэглэгдэхээ больж байна. Үгчилбэл энэ нь орлоготой хүн ам гэсэн утгатай. Тийм учраас хөдөлмөр эрхэлдэг хүн ам гэдэг нь орлогынх нь эх үүсвэрээр хүн амын хуваарилалтыг харуулсан нэр томьёо болж байна. Жишээ нь, хүн амын тооллогын хуудсанд хөдөлмөр эрхэлдэг эсэх, стипенди авдаг эсэх, тэтгэвэр авдаг эсэх гэх мэт асуултууд байдаг.


Эдийн засгийн идэвхтэй хүн ам гэдэг ойлголт нь НҮБ-ын хэмжээнд боловсруулагдаад хэрэгжиж байгаа нэр томьёо ба эдгээр хүн ам нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд орох чадвартай хүн ам юм. Энэ нь үндэсний тооцооны системтэй уялдсан материал баялаг, үйлчилгээний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа гэсэн үг.

Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог дараахи томьёогоор тооцно.

$$\text{Хөдөлмөрийн насны хүн ам} - \text{улсын болон хувь хүний асрамжинд байдаг хүмүүс} = \text{хөдөлмөрийн насны эдийн засгийн идэвхтэй хүн ам}$$

$$\text{Хөдөлмөрийн насны эдийн засгийн идэвхтэй хүн ам} + \text{насанд хүрээгүй ажиллагсад ба тэтгэврийн хүмүүс} = \text{эдийн засгийн идэвхтэй хүн ам}$$

Нийт хөдөлмөрийн нөөц. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага 1954 оноос эхлэн энэ нэр томьёог олон улсын хэмжээнд хөдөлмөрийн хүчин чадлыг тодорхойлоход ашиглаж иржээ. Энэ байгууллага нь олон улсын статистикаар идэвхтэй үйл ажиллагаа явуулахаас гадна хөдөлмөрийн талаарх үзүүлэлтүүдийг тооцох аргачлалаар хөдөлмөрийн статистикаас гадна хүн амын үзүүлэлтүүдийг тусгасан тодорхой эмхтгэл, товхимлыг хэвлэдэг. Тэдгээрийн дотор Labour Force Statistics чухал байр эзэлдэг. Тухайлбал: 1990-ээд оны АНУ-ын хөдөлмөрийн нөөцийн үзүүлэлтүүдийн талаар үзүүлсэн схемийг харья.



Хүн ам	Бүгд	Үүнээс	
		ХАА, ан, загас агнуур, ойн аж ахуй	Бусад салбар
Бүх хүн ам	116.9	3.4	113.5
Үүнээс:			
1. Хөлсний ажилчид	106.4	1.8	104.6
2. Компанийн эзэд	10.2	1.5	8.7
3. Гэр бүлийн туслах ажилчид	0.343	0.119	0.224

Хүснэгтээс харахад нийт ажиллагсдын 3.4 хувь нь ХАА, ан, загас агнуур, ойн аж ахуйн салбарт ажиллаж байв. Өөрөөр хэлбэл, нийт ажиллагсдын 3.4 хувь нь улс орныг газар тариалан, ойн аж ахуй, загас агнуурын бүтээгдэхүүнээр хангаж байна гэсэн үг.

Хөдөлмөрийн насны хүн амыг тодорхойлох гол үндэс нь хүн амын нас хүйсний бүтэц байдаг. Ийм учраас хөдөлмөрийн хүчин чадлыг тодорхойлох статистик судалгааны үндсэн нөхцөл нь хүн амын судалгаа юм. Энэ судалгааг хийхийн тулд төрөлт, нас баралт, ердийн хөдөлгөөний ерөнхий болон нас хүйсийн коэффициент, хүн амын цэвэр өсөлт, механик хөдөлгөөний коэффициентийг тодорхойлдог хүн амын ердийн болон механик хөдөлгөөний үзүүлэлтүүдийг ашигладаг.

Эдгээр коэффициентүүд тухайн үзүүлэлтийн (төрөлт, нас баралт, шилжиж ирсэн, шилжин явсан, ердийн болон механик хөдөлгөөн) абсолют утгыг хүн амын жилийн дундаж тоонд харьцуулдаг нэгдсэн аргачлалаар тодорхойлогддог.

Ийм маягаар мөн хөдөлмөрийн насны хүн амын ердийн болон механик хөдөлгөөний коэффициентүүдийг тооцдог. Энэ тохиолдолд коэффициентийн дээд талд нь зөвхөн хөдөлмөрийн насны хүн амын хөдөлгөөний абсолют үзүүлэлтийг, доод талд нь хөдөлмөрийн насны хүн амын дундаж тоо байна. Үүнээс гадна шилжин ирэлтийн үзүүлэлтэд хөдөлмөрийн насны биш мөртлөө тухайн үед хөдөлмөр эрхэлж байгаа хүн амыг авдаг. Харин шилжин явалтын үзүүлэлтэд өндөр насны болон тахир дутуугийн тэтгэвэрт гарсан, мөн хөдөлмөрийн насны нас барсан хүн амыг авдаг.

Хөдөлмөрийн насны хүн амын тоо нь улс орны цэргийн болон хөдөлмөрийн хүчин чадлыг тодорхойлохоос гадна түүнийг эдийн засгийн идэвхтэй хүн амаас ялгаж ойлгох хэрэгтэй. Эдийн засгийн идэвхтэй хүн ам гэдэг нь хөдөлмөрийн насны хүн амаас бага байдаг ба түүнд эдийн засгийн үйл ажиллагаанд ямар нэгэн шалтгаанаар үл оролцдог хүн амыг оруулдаггүй.

Эдийн засгийн идэвхтэй хүн амд тухайн үе хугацаанд эдийн засгийн таваар үйлчилгээг үйлдвэрлэхэд өөрийн хөдөлмөрөө оруулдаг бүх хүн амыг хамран оролцуулдаг. Эдийн засгийн идэвхтэй хүн амын талаар үндсэн 2 ойлголт байдаг. 1) ерөнхий идэвхтэй хүн ам – энэ томъёолол нэлээд удаан хугацааны судалгаанд ашиглагддаг (жилийн); 2) тухайн үеийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч) – богино хугацаанд хийгдэх судалгаанд ашиглагддаг (нэг хоног, долоо хоног).

Дэлхийн улс орнуудад зэвсэгт хүчин, хоригдол, анхныхаа ажил хайгчид, улирлын чанартай ажилчид, бүтэн биш ажлын өдөртэй ажилчид гэх мэт ойлголтууд нь ялгаатай байдаг. Зарим оронд эдгээр бүлэг хүмүүс бүгдээр болон хэсгээр эдийн засгийн идэвхтэй хүн амд харьяалагддаг бол зарим оронд тэд ажил эрхэлдэггүй хүн амд харьяалагдах жишээтэй. Эдийн засгийн идэвхтэй хүн амд оюутнууд, ажил эрхэлдэггүй гэрийн эзэгтэй нар, өндөр насны тэтгэврийн хүн ам, өөрийнхөө хадгаламжийн үндсэн дээр амьдрагч хүн ам, бусдын эрхшээлд байгаа хүн ам орохгүй. Эдийн засгийн идэвхтэй хүн амыг тооцохын тулд бүлэглэлтийн аргыг өргөн хэрэглэдэг. Эдгээр бүлэглэлт нь нийт хүн амын болон нийгэм-эдийн засгийн гэсэн 2 хэлбэртэй байдаг.

Нийт хүн амын бүлэглэлт нь эдийн засгийн идэвхтэй хүн амыг авч үзэхээс гадна нийт хүн амыг мөн хамардаг. Бүлэглэлтийн дараах хэлбэрүүдийг дурьдаж болох юм. Үүнд:

- нас, хүйсийн бүлэглэлт;
- улс орнуудын засаг захиргааны хуваарилалтын үндсэн дээр хийгддэг газар нутгийн бүлэглэлт (хүн амын оршин суугаа газраар нь), хот хөдөөгийн хүн амын бүлэглэлт;
- гэр бүлийн байдлаар хийх бүлэглэлт (гэрлэсэн, ганц бие, салсан, бэлбэсэн), мөн гэр бүлийн гишүүдийн тоогоор хийх бүлэглэлт;
- яс үндэс, төрөлх хэлээр хийх бүлэглэлт (оршин суугч бүр өөрийгөө тодорхойлох зарчмын үндсэн дээр);
- аль улсын иргэн гэсэн бүлэглэлт;
- боловсролын түвшингээр хийх бүлэглэлт;
- орлогын эх үүсвэрээр хийх бүлэглэлт (хөдөлмөрийн орлого, тэтгэвэр, тэтгэлэг, стипенди, капиталын орлого, хүү, түрээсийн орлого, иждивенцы гэх мэт).

Нийгэм-эдийн засгийн бүлэглэлт нь эдийн засгийн идэвхтэй хүн амыг тодорхойлоход ашиглагдана. Энэ бүлэглэлтэнд ОУХБ-ын баталсан Олон улсын статусын ангиллын хүрэн дэх ажил эрхлэлтийн байдлын талаарх бүлэглэлт хамаарна.

Олон улсын статусын ангилал нь ажил олгогч, биеэ даасан эзэд, хөлсний ажилчид, гэр бүлийн бизнест хөлс авдаггүй гишүүд, үйлдвэрлэлийн хоршооллын гишүүд гэсэн категориудаар эдийн засгийн идэвхтэй хүн амыг тодорхойлдог. Статус болгоны олон улсын стандартын тодорхойлолтыг үзье.

- *Ажил олгогч*: хувийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, нэг болон түүнээс дээш тооны хөлсний ажилчдыг ажиллуулдаг.
- *Бие даасан эзэн*: хувийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, хөлсний ажилчдыг ажиллуулдаггүй.
- *Хөлсний ажилчин*: улсын болон хувийн байгууллагад ажиллаад хийсэн ажлынхаа төлөө цалин хэлбэрээр шагнал авдаг.
- *Хөлс авдаггүй ажилчин*: өрхийн гишүүн бөгөөд өрхийн бизнест ажиллаад хөлс авдаггүй.
- *Хоршооллын гишүүн*: үйлдвэрлэлийн үйл ажиллагааны салбараас үл харгалзан хоршоололд нэгдсэн үйлдвэрлэгчдийн бүлгийн гишүүн.

- Статусаар ангилагдаагүй ажилчин: статус нь тодорхойгүй, урьд нь ажиллаж байгаагүй ажилгүйчүүд.

Олон улсын статусын ангиллаас үл хамааран дэлхийн улс орнуудын статистикийн бүртгэлд зэрэгцүүлж болохгүй тийм тодорхойлолтууд хадгалагдсаар байна. Жишээ нь удирдах ажилтан, захирлууд зарим тохиолдолд хөлсний ажилчин шиг ангилагддаг, харин зарим тохиолдолд тэднийг ажил олгогчийн түвшинд авч үздэг. Өрхийн бизнес дэх хөлсний бус ажилчид бараг ихэнх орнуудад эдийн засгийн идэвхтэй хүн амд тооцогддог. Ажил олгогч, бие даасан эзэд заримдаа хамт тооцогддог. Ихэнх орнуудад хийсэн хөдөлмөрийнхөө төлөө цалин хэлбэрээр хөлс авдаг өрхийн ажилчид нь хөлсний ажилчид шиг ангилагдахаас гадна зарим үед тэднийг өрхийн ажилчдын категорид хамааруулж ангилдаг. Статусын ангилал болон ажилгүйчүүд улс орнуудад өөр өөрөөр тодорхойлогддог тал бий.

Эдийн засгийн идэвхтэй хүн амын нэлээд чухал бүлэглэлт бол ажиллагсад ба ажилгүйчүүд гэсэн бүлэг юм. Энэ бүлэглэлт нь 1982 онд Женевт болсон Ажиллах хүчний статистикийн олон улсын XIII бага хурлаар баталсан ажиллагсад ба ажилгүйчүүдийн тодорхойлолтон дээр үндэслэгдсэн байдаг. Үүнтэй уялдан ажиллагсад ажиллах насны доод хязгаараас дээш насны хүмүүс хамаардаг.

I. Толбөртэй ажиллагсад: а) ажилчид - тайлангийн хугацаанд цалин авахын тулд ажил гүйцэтгэсэн ажилчид; б) тайлангийн хугацаанд байгаагүй ажилчид - ажиллагсдын тоонд орж байгаа мөртлөө түр хугацаагаар ажил дээрээ байгаагүй, зөвхөн ажлын газартайгаа холбоотой байдаг ажилчид. Тухайлбал, цалингийн тооцоо үргэлжилсэн хэвээр, гэнэтийн нөхцөл байдал тохиолдсоны дараа эргээд ажилдаа орох баталгаатай, ажил дээрээ түр эзгүй байгаа тэтгэлэгт хамрагддаг ажилчид.

II. Бие даасан ажиллагсад: а) ажиллаж байгаа эзэн - тайлангийн хугацаанд ашиг буюу өрхийн орлогыг бэлэн болон биет (натурал) хэлбэрээр авах зорилгоор ажил хийсэн хүмүүс; б) ажил хийгээгүй эзэн - хэдийгээр хувийн бизнестэй боловч ямар нэгэн шалтгаанаар түр ажил хийгээгүй хүмүүс;

Олон улсын статистикийн эмхэтгэлүүдэд (бага хэмжээний, тухайлбал цагийн ажил гэх мэт) “зарим ажил” гэсэн ойлголт тааралддаг.

Өвчин, гэмтэл, баяр ёслол, амралт, бослого, үйлдвэр хаагдаж ажилчид ажилгүй болсон, боловсрол эзэмших, мэргэжил дээшлүүлэх, жирэмсний амралт, хүүхэд өвдсөн, агаар муугаас болон механик, цахилгаан гэмтэл гарсан, түүхий эд, материал, түлш хүрэлцээгүйгээс ажил хийх боломжгүй болсон зэрэг шалтгааны улмаас ажилдаа түр ирээгүй хүмүүс ажилтайгаа холбоотой тохиолдолд “төлбөртэй ажиллагсдад” хамаарна.

Ажил олгогчид, бие даасан эзэд, үйлдвэр хоршооллын гишүүд “бие даасан ажиллагсдад” хамрагдах ба ажиллаж байгаа эзэн, ажиллаагүй эзэн гэсэн ангилалд хуваагдана. Өрхийн бизнест байгаа төлбөргүй ажиллагсад ажилласан цагийн тооноос үл харгалзан бие даасан ажиллагсдад хамаарна.

Өрхийн төлбөргүй ажилладаг гишүүдийг ажиллагсдад хамруулдаг улс орон хөлсгүйгээр ажиллах хугацааны хязгаарыг тогтоож өгдөг (долоо хоногт 15 цаг).

Өрхийн аж ахуйн орлогын ихэнх хэсгийг эзэлдэг, өөрийн болон гэр бүлийнхээ хэрэгцээнд зориулж таваар үйлчилгээ явуулдаг хүмүүс бие даасан ажиллагсдад хамаарна.

Бэлэн болон биет (натурал) хэлбэрээр хөлс авдаг сурагчид төлбөртэй ажиллагсдад хамаарах бөгөөд ажиллаж байгаа эзэн юм уу, эсвэл ажил хийдэггүй эзэн гэсэн категорид ордог.

Оюутнууд, гэрийн эзэгтэй нар болон үндсэндээ эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг бусад хүмүүс ажиллагсдад хамаарахаас гадна болж өгвөл тусад нь тооцох хэрэгтэй.

Цэргийн хүмүүс тогтмол болон түр ажилтай гэсэн хоёр хэлбэрээр төлбөртэй ажиллагсдад хамаарна

Ажилгүйчүүд гэдэг нь ОУХБ-ын тодорхойлсноор ажиллах насны доод хязгаараас дээш насны хүмүүс юм. Тэдгээрийг дараахитөрөлд хуваана. Үүнд:

а) ажилгүй, өөрөөр хэлбэл төлбөртэй болон бие даасан ажиллагсдад хамаарахгүй хүмүүс;

б) ажиллахад бэлэн, тухайлбал төлбөртэй болон бие даасан ажиллагсдад хамаарахад бэлэн хүмүүс;

в) ажил хайж байгаа буюу төлбөртэй болон бие даасан ажиллагсад хамаарахад тодорхой хэмжээний алхам хийсэн хүмүүс. Тодорхой алхмууд гэдэг нь улсын болон хувийн хөдөлмөрийн бирж дээр бүртгэгдсэн; ажил олгогчид өргөдөл өгчихсөн; ферм, үйлдвэрийн газар, зах болон бусад газруудад ажил хайсан; сонингоор зар өгсөн, хариу авсан; найз нөхөд болон хамаатан садандаа тусламж хүсэж хандсан; өөрийн гэсэн бизнес хийхээр газар, байр, машин, тоног төхөөрөмж, санхүүгийн эх үүсвэр түрээсээр авах оролдлого хийсэн; ямар нэгэн үйл ажиллагаа хийхээр зөвшөөрөл, лиценз хүлээж байгаа хүмүүс юм.

Ажил хайх дээрх нөхцлүүд хэрэгжээгүй, хөдөлмөрийн зах зээл зохион байгуулагдаагүй юм уу хязгаарлагдмал улс орнуудад ажилгүйчүүд гэдэг ойлголт өөр шинж тэмдгээр тодорхойлогддог.

Ажилд ороход бэлэн байгаа гэсэн критерийг хэрэглэхэд үндэсний онцлогийг тусгасан тест боловсруулах шаардлагатай. Эдгээр тестүүд нь дараах ойлголтон дээр үндэслэгдэнэ. Үүнд: тухайн ажилгүй болсон хүн одоо ажиллах хүсэлтэй байгаа эсэх; урьд ажиллаж байсан ажилдаа хир туршлагажсан; цалин авахын тулд ажиллахад бэлэн эсэх; хэрэгцээтэй нөөц, хэрэгсэл бэлэн байгаа тохиолдолд бие даасан үйл ажиллагаа эхлэхэд бэлэн эсэх орно.

Ажилгүйчүүдийн талаарх үндэсний онцлогийг харгалзсан тодорхойлолт нь олон улсын стандартаас ялгаатай. Улс орнуудад насны хязгаар, ажиглалтын үе хугацаа, ажил хайх критери, түр халагдсан буюу шинээр ажил хайж байгаа хүмүүсийг өөр өөрөөр тодорхойлдог.

Ажилгүйчүүдийн судалгаа хийхэд дараах үзүүлэлтүүдийг ашигладаг. Үүнд:

Ажилгүйчүүдийн түвшин — эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд ажилгүйчүүдийн тооны эзлэх хувь юм.

Ажилгүйчүүдийн үргэлжлэх хугацаа (ажил хайх хугацаа) — ажил хайж эхэлснээс хойш төрөл бүрийн арга ашиглан ажил хайсан хэсэг хугацаа юм.

Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо, ажиллагсад, ажилгүйчүүдийн тооны үндсэн дээр хөдөлмөрийн идэвх, ажиллагсад, ажилгүйчүүдийн *коэффициентийг* тодорхойлдог ба ажиллагсад, ажилгүйчүүдийн *коэффициентийг* хоёр аргаар тодорхойлж болдог. Үүнд: а) бүх хүн амын тоонд харьцуулж; б) эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж гаргадаг.

Ажилгүйчүүдийн тоон дээр ажиллагсдын тоог нэмэхэд эдийн засгийн идэвхтэй хүн амын нийт тоо гарах нь ойлгомжтой. Тийм учраас ажиллагсад, ажилгүйчүүдийн коэффициентийг нэмэхэд 1 гарна.

Ажилгүйчүүдийн дундаж тоо – тодорхой хугацаанд ажилгүй байсан ажилгүйчүүдийн тоог тэдгээр сарын тоонд харьцуулж гарна.

Хөдөлмөрийн зах (бирж) дээрх хүчин чадлын коэффициент – ажил эрхлээгүй хүн амын тоог зарлагдсан ажлын байрны тоонд харьцуулж гаргана.

Ажилгүйчүүдийг урт хугацааны (1 жилээс 2 жил хүртэл ба 2 жилээс дээш) болон богино хугацааны (3 сар хүртэл ба 3 сараас 1 жил хүртэл) гэж хоёр хуваадаг.

ОУХБ-ын заавраар ажиллагсад, ажилгүйчүүд гэсэн ойлголтуудын зэрэгцээ ажилтай мөртлөө бүтэн биш хугацаагаар ажилладаг ажиллагсад гэсэн ойлголт байдаг. Хийж байгаа ажлаасаа гадна нэмж ажил хийх сонирхол байвч санаснаар болдоггүй. Ийм ажиллагсдын тоонд бүтэн ажиллаж байгаа боловч өөрийнхөө эзэмшсэн мэргэжлээс доогуур түвшинд ажилладаг хүмүүс ордог учраас бага хэмжээний цалин авдаг, гэвч цаашид нэмэгдэх нь зайлшгүй. Бүтэн биш хугацаагаар ажилладаг ажиллагсдыг тодорхойлох шалгуур нь ажилласан цаг, авсан орлого юм.

Бүтэн биш хугацаагаар ажилладаг ажиллагсдыг янз бүрийн аргаар тооцдог ба эдгээр аргуудын ихэнх нь судалгааны тусламжтайгаар нэлээд нарийн гардаг.

Бүтэн биш хугацаагаар ажилладаг ажиллагсдыг дараахи хэлбэрт хуваана:

- “ил” бүтэн биш хугацаагаар ажилладаг ажиллагсад – ажлын цагийн үргэлжлэх хугацаа нь энгийнхээс бага байдаг. Ажлын календарийн хугацаанд бүтэн биш хугацаагаар ажилласан ажиллагсад хамаарна.
- “далд” бүтэн биш хугацаагаар ажилладаг ажиллагсад – бүтэн ажлын өдөр ажиллаад бусад газрын цалингаас доогуур цалин авдаг, эсвэл өөрийн мэргэжлийн түвшингээс доогуур ажил хийдэг ажиллагсад хамаарна. Мөн доогуур түвшингийн хөдөлмөрийн бүтээмжтэй салбарт ажиллагсад орно.

Өөрийнхөө хүсэлтээр бүтэн биш ажлын өдөр ажилласан ажиллагсад (эмэгтэйчүүд, хүүхдүүд, настай хүмүүс) энд хамаарахгүй.

Бүтэн биш хугацаагаар ажилладаг ажиллагсдыг тодорхойлохдоо ажиллагсдын категори бүрийн ажлын өдрийн үргэлжлэх хугацаатай харьцуулахын тулд ажлын өдрийн үргэлжлэх бодит хугацааг мэдэж байх шаардлагатай. Бүтэн биш хугацаагаар ажилладаг ажиллагсдад ажлын өдрийн тогтсон үргэлжлэх хугацааны 80 хувиас доош ажилласан хүмүүс хамаарна. Дөчин цагтай ажлын долоо хоногт 32 цагаас доош ажилласан хүмүүс энэ категорид хамаарна. Бүтэн биш хугацаагаар ажилладаг ажиллагсдын тооны талаар статистикийн мэдээний эх үүсвэр бол хүн амын тооллогын материал, тусгай түүвэр судалгааны материал юм.

Түүнээс гадна бүтэн биш хугацаагаар ажилладаг ажиллагсдын тоог гаргахдаа ажиллагсдын бодит тоог хөдөлмөрийн бүтээмжийн дундаж түвшинтэй, үйлдвэрлэлийн техникийн дундаж түвшинтэй, үйлдвэрийн ажиллагсадтай харьцуулах замаар тооцдог.

Хэрэв бүтээгдэхүүний хэмжээг хөдөлмөрийн бүтээмжийн дундаж түвшинд харьцуулбал ажиллагсдын зайлшгүй тоо гарна.

Ажиллагсдын илүүдэл тоо нь ажиллагсдын тухайн үеийн тоо, зайлшгүй тоо хоёрын ялгаа юм.

Улс орны ажилгүйчүүдийн албан ёсны тоо нь бодит тооноосоо нуугдмал ажилгүйчүүдийн тоогоор бага байдаг. Судлаачдын үзэж байгаагаар ажилгүйчүүдийн тодорхой хэсэг нь ажлаас гарсныгаа бүртгүүлдэггүй, өөрсдөө өөр ажил хайгаад явдаг. Нуугдмал ажилгүйчүүдэд ажиллах хүчний үнэ цэнийг бууруулсан бүтэн хугацаагаар ажилладаггүй ажиллагсад хамаарах ба хөдөлмөрийн зах дээрх эрэлт хэрэгцээг дутуу тодорхойлоход хүргэдэг.

Эдийн засгийн судалгаанд ажиллагсдыг нийгмийн болон мэргэжлийн бүлгээр хуваах явдал чухал. Дараах бүлэгт хувааж болох юм. Үүнд:

- хууль тогтоогчид, удирдах ажилтнууд, менежерүүд;
- мэргэжилтэнгүүд, техникчид, туслах мэргэжилтэнгүүд;
- ажиллагчид;
- худалдаа, үйлчилгээний салбарын ажиллагчид;
- хөдөө аж ахуй, ойн аж ахуйн мэргэжилтэй ажиллагчид;
- үйлдвэрийн ажилчид, гар урчууд;
- фабрик, заводын операторчид, угсрагчид;

- энгийн ажлууд (эдийн засгийн бүх салбарт);

- батлан хамгаалах хүч.

Ажиллагсдыг эдийн засгийн салбараар ангилж болно. Улс орон болгонд өөрийн гэсэн салбарын бүлэглэлт байдаг. Дээрх ангиллыг хийхэд НҮБ-ын Статистикийн комисс дараах салбарыг санал болгодог. Үүнд:

1. хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, ан;
2. олборлох аж үйлдвэр;
3. боловсруулах аж үйлдвэр;
4. эрчим хүч, хий, усны үйлдвэрлэл;
5. барилга;
6. худалдаа, зочид буудал, ресторан;
7. тээвэр, холбоо, складын аж ахуй, нийтийн аж ахуйн үйлчилгээ;
8. санхүү, даатгал, үйлдвэрийн газрын үйлчилгээ;
9. хувийн, хамт олны, нийгмийн үйлчилгээ;
10. эдийн засгийн үйл ажиллагааны бусад хэлбэрүүд.

Зарим улс энэ ангиллаас гадна ажилгүйчүүдийн тоо, батлан хамгаалах хүчийг тусад нь тооцдог.

Ажиллагсдын нийгмийн бүлэг, мэргэжлийн байдлыг харуулсан бүлэглэлт хийхийн тулд улсын хэмжээний хөдөлмөрийн нөөцийг 11 бүлэг болгон хуваадаг. Эдварсын ангиллыг ашигладаг.

“Цагаан захтангууд”:

1. мэргэжилтнүүд;
2. удирдах ажилтнууд (түшмэлүүд, өмч эзэмшигчид);
3. конторын ажиллагчид болон тэдний хамаатангийн хүмүүс;
4. худалдааны ажиллагчид;

“Хөх захтангууд”:

5. мастерууд, мэргэжлийн ажилчид;
6. хагас мэргэжсэн ажилчид (фермүүдэд ажиллагсад орохгүй);
7. мэргэжилгүй ажиллагсад (фермүүдэд ажиллагсад орохгүй);
8. гэрийн зарц;
9. үйлчилгээний ажилчид;

Фермерүүд:

10. фермерүүд, удирдах ажилтангууд;

11. хөлсний ажилчид, фермийн ажиллагсад.

Ажиллагсдыг ажлын цагийн үргэлжлэх хугацаагаар нь (ажлын долоо хоногийн цагийн үргэлжлэх хугацаа) бүлэглэх явдал маш чухал. Ажлын цагийн ашиглалтын коэффициентийг ажлын цагийн тухайн үргэлжлэх хугацааг тогтоогдсон ажлын цагийн үргэлжлэх хугацаанд хувааж гаргана.

Жишээ нь, тогтоогдсон ажлын цагийн үргэлжлэх хугацаа 39 цаг гэвэл ажлын цагийн тухайн үргэлжлэх хугацаа 38,7 цаг байна. Ажлын цагийн ашиглалтын коэффициент $38,7:39,0=0,992$ буюу 99,2 хувь байна. Мөн жилийн ажлын цагийн үргэлжлэх хугацааг 1692 цаг (тогтоогдсон хугацаа 1732 цаг) гэвэл ажлын цагийн ашиглалтын коэффициент: $(1692:1732)\times 100=97,7$ хувь болно.

Ажилгүйчүүдийн хувьд ажилгүй байх хугацаагаар нь тусгай бүлэглэлт хийдэг. ОУХБ-ын санал болгосноор ажилгүй байх үеийн интервалыг 3 сар хүртэл; 3 сараас 1 жил хүртэл; 1 жилээс 2 жил хүртэл; 2 жилээс дээш гэж хуваадаг. Мөн ажилгүйчүүдийн тэтгэлэг авдаг эсэхээр нь, ажилгүй байх хугацаандаа алдсан цагаар нь, нийтийн хөдөлмөрт оролцсон эсэхээр бүлэглэж болно.

Хөдөлмөрийн зах зээлийг тодорхойлохын тулд ажлын байрны сул орон тооны статистикийг гаргадаг. Энэ нь ажилгүйчүүдийг ажлын байраар хангах үзүүлэлтийг тооцоход хэрэгтэй. Энэ үзүүлэлтийг тооцохдоо бэлэн байгаа ажлын байрны тоог ажилгүйчүүдийн тоонд харьцуулж гаргана.

Ажиллагсдын талаарх дээрх бүлэглэлтүүдийг эдийн засгийн судалгаанд өргөн ашиглаж байна.